

Корона-цар тахалыг зогсооход та ч гэсэн тусалж чадна

Коронавируст халдвар (SARS-CoV-2) нь дэлхий даяар тархаад байгаа бөгөөд энэ хэвээрээ үргэлжилж ч магадгүй байна. Гэсэн хэдий ч вирусыг бидэнд заналхийхгүй байх нөхцлийг бид хамтдаа бүтээж чадна. Ингэснээр цар тахал үгүй болж бид бүгд дахин хэвийн амьдралаар хамтдаа амьдрах боломжтой болно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд БҮГДЭЭРЭЭ туслах ёстой.

Вакцинжуулалт

Коронавирусын эсрэг вакцин нь таныг төдийгүй мөн бусдыг энэхүү халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болно. Олон хүн вакцинд хамрагдсанаар вирусын аюул багасна. Улмаар олон хүн хүнд өвчнөөр өвчлөхгүй, эмнэлэгүүдийн орны хүрэлцээ ч нэмэгдэх боломжтой. Германд амьдарч буй бүх хүмүүст вакцинжуулалт сайн дурын үндсэн дээр үнэгүй хийгдэж байна. Тиймээс вакцин хийлгэхэд хэн ч мөнгө төлөх шаардлагагүй, хэнийг ч албадахгүй. Гэхдээ зөвхөн олон хүн вакцинд хамрагдсан тохиолдолд л бид Корона-цар тахалаас ангижирч чадна.

Хаана, хэзээ вакцинд хамрагдах

Одоогийн байдлаар; 2021 оны 5-р сард Герман улсад хүн бүр нэн даруй вакцинд хамрагдах цаг авах хэмжээний вакцины хангамж хангалттай бус байна. Иймд вакцинд хамрагдах дараалалыг гаргасан. Коронавируст нэн эрсдэлтэй хүмүүс эхний ээлжинд вакцинжуулалтанд хамрагдах болно. Липпе дүүргийн вэбсайт дээр вакцинжуулалтанд хэн хамрагдах боломжтой талаар мэдээлсэн: www.kreis-lippe.de/corona/impfung ба вакцин хийлгэх цагийн талаар дараагийн хэсэгт дурьдах болно.

6-р сар гэхэд хүн бүр вакцин хийлгэх цаг авсан байх ёстой.

Вакцин хийлгэхийг хүссэн хүн бүрт өрхийн эмч нар Астра зенека (AstraZeneca) вакциныг хийх боломжтой болсон. Тодорхой дарааллын улмаас цаг авах шаардлагатай хүмүүс Лемго дахь вакцинжуулалтын төвд хандан вакцинд хамрагдаж болно. Олон хүн амьдардаг нийтийн байранд явуулын баг очиж вакцинжуулалтыг хийнэ.

Вакцин хийлгэх цаг авах

Вакцин хийлгэх цаг авах олон боломжууд бий. Вакцинжуулалтын төвд юмуу эсвэл онлайнаар www.terminland.de/impfzentrum-lippe мөн дараах вэбсайт www.corona-kvwl.de/impftermin эсвэл утсаар 0800 116117 02 холбогдон вакцин хийлгэх цаг авах боломжтой. Хэрвээ та өөрийн эмч мэргэжилтнүүдээс асуувал тэд бусад хүмүүст мөн адил анхаарал тавих ёстой гэдгийг санахад илүүдэхгүй. Тэд хэн, хаана вакцинд хамрагдах цаг авах талаар зааварчлага өгч чадах хэдий ч бараг л өдөр бүр холбогдох дүрэм журам шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа тул та өөрөө урьдчилан интернетээр харсан нь илүү дээр байх болно. Вакцинд хамрагдаж цаг авах талаарх мэдээллийг тухайлбал Липпе дүүргийн танилцуулга болон вэбсайтаас авч болно.

Бусад тус болох зүйлс

Хангалттай олон хүмүүс вакцинд хамрагдах хүртэл бид хоорондын зайгаа барьж, бусад хүмүүстэй бага харилцах шаардлагатай. Эс бөгөөс эмнэлгүүд дүүрсэн, дэлгүүр худалдааны төвүүд хаалттай, уулзалт хийх нь хориотой хэвээр байх болно. Бид амны хаалтаа цаашид ч зүүх шаардлагатай. Одоогийн байдлаар Коронавирусын түргэвчилсэн шинжилгээ хийх төвүүд олон газар ажиллаж байна. Энэхүү шинжилгээ нь үнэ төлбөргүй. Мөн түүнчлэн Корона Сэрэмжлүүлэх-программыг (App) олон хүмүүс ашигладаг бол энэ нь бас тус болно.



Илүү тодорхой мэдээллүүдийг хаанаас олж болох вэ

Корона болон вакцинжуулалтын талаарх мэдээлэл нилээдгүй бий. Харамсалтай нь буруу мэдээллүүд мөн адил их байгаа бөгөөд аль нь үнэн, аль нь буруу гэдгийг ялган мэдэхэд амаргүй юм.

Зөвхөн найдвартай мэдээллийн эх сурвалжид итгэх хэрэгтэй. Герман улсын хувьд Коронагийн талаарх үнэн бодит мэдээллийг дараах эх сурвалжуудаас олж авч болно: Роберт Кох Институт (RKI) www.rki.de, Холбооны эрүүл мэндийн яам (BMG)

www.bundesgesundheitsministerium.de эсвэл


www.zusammengegencorona.de мөн Холбооны эрүүл мэндийн боловсролын төв (BZgA)

www.infektionsschutz.de.

Мэдээжийн хэрэг та урьд нь очиж байсан эмчээсээ ч асууж болно.

2021 оны 5-р сарын 7-ны мэдээлэл

Та манай нүүр хуудас www.ki-lippe.de, инстаграм @ki_kreislippe болон YouTube ki_kreislippe сувгаас биднийг онлайнаар олох боломжтой.



Коронавирусын эсрэг вакцин*

Германд үр дүнтэй, аюулгүй 4 төрлийн вакцин зөвшөөрөгдсөн

Үйлдвэрлэгчид нь BioNTech/Pfizer, Moderna, AstraZeneca, Johnson&Johnson. BioNTech/Pfizer, Moderna, AstraZeneca вакциныг 2 давталттай, харин Johnson&Johnson вакциныг нэг л удаа хийлгэх ёстой.



Дэлхий даяар олон мэргэжилтнүүд зэрэг ажилласан учраас коронавирусын эсрэг вакциныг богино хугацаанд бүтээж чадсан. Энэхүү судалгааг түргэн шуурхай хийхэд их хэмжээний мөнгө зарцуулсан. Үүнээс гадна коронавирус нь шинэ вирус биш бөгөөд эрдэмтэд ижил төстэй вирусын талаар нилээдгүй мэддэг байсан. Коронавирус нь дэлхий даяар хурдтай тархсан тул үүний эсрэг вакциныг мөн богино хугацаанд туршиж чадсан.

Германд шинэ вакцинд зөвшөөрөл олгохын тулд маш нарийн тодорхой туршиж үздэг. Тухайн вакциныг хэрэглэхийг зөвшөөрөгдсөний дараа ч гэсэн үргэлжлүүлэн хяналт тавьдаг. Дэлэгрэнгүй мэдээллийг дараах сайтаас уншиж болно: www.zusammengegencorona.de/impfen/impfstoffe/so-sicher-ist-die-corona-schutzimpfung

Вакцинжуулалт нь коронавирусын гаралтай хүнд өвчнөөс хамгаална

КОВИД-19 халдварын үед илрэх нийтлэг шинж тэмдэгүүд




КОВИД-19 халдварын үед илрэх болзошгүй хүндрэлүүд



Вакцин хийлгэсний дараа илрэх нийтлэг хариу урвал

Вакцин хийлгэсний дараа бие махбодод вакцины эсрэг хариу урвал мэдрэгдэж болзошгүй. Энэ нь дархлалын систем ажиллаж байгаагийн шинж тэмдэг. Ингэх нь сайн бөгөөд вакцин нөлөөлж буйн нэг илрэл юм. Ихэнх тохиолдолд 24 цагийн дараа хариу урвал арилдаг.



Та манай нүүр хуудас www.ki-lippe.de, инстаграм @ki_kreislippe болон YouTube ki_kreislippe сувгаас биднийг онлайнаар олох боломжтой.

Kommunales Integrationszentrum Kreis Lippe

KREIS LIPPE
Heimat geben. Zukunft bieten.

*Эх сурвалжууд: Europäische Zulassung, Empfehlung der Ständigen Impfkommission, Impfverordnung des Bundesministeriums für Gesundheit, Zusammen gegen Corona